

**МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ХООРООНД МОНГОЛ УЛСААС БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСАД СҮҮ,  
СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭРИЙН  
ШААРДЛАГЫН ТУХАЙ ПРОТОКОЛ**

Монгол Улсын Гаалийн ерөнхий газар (цаашид “Монгол Улсын ГЕГ” гэх) болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар (цаашид “БНХАУ-ын ГЕГ” гэх) хоорондын Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид “БНХАУ” гэх)-д сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох хяналт шалгалт, хорио цээрийн шаардлагын талаарх асуудлыг нөхөрсгөөр хэлэлцэн дараах зүйлсийг тохиролцов.

**1 дүгээр зүйл**

Монгол Улсын ГЕГ нь Монгол Улсаас БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүний хяналт шалгалт, хорио цээрийг хариуцаж “Эрүүл ахуйн гэрчилгээ”-г олгоно.

**2 дугаар зүйл**

Монгол Улсын ГЕГ нь Монгол Улсын сүүний чиглэлийн амьтны эрүүл ахуйн хууль, журам; сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчтэй холбогдол бүхий хууль, журам; сүү, сүүн бүтээгдэхүүний чанарын аюулгүй байдлын холбогдох хууль журам болон экспортлох гэж буй сүү, сүүн бүтээгдэхүүний хорио цээрийн хяналт, аргачлал, дэс дараалал, стандартын талаарх хууль, дүрэм журмаар БНХАУ-ын ГЕГ-ыг хангана. Мөн албан ёсны тамга тэмдгийн дардас, үнэт цаасан дээр хэвлэсэн “Эрүүл ахуйн гэрчилгээ”-ний загвараар хангах бөгөөд аль нэг бичиг баримтад өөрчлөлт орсон тохиолдолд нэг сарын өмнө БНХАУ-ын ГЕГ-т мэдэгдэнэ.

**3 дугаар зүйл**

Монгол Улсын ГЕГ нь БНХАУ-ын ГЕГ-ын шаардлагыг үндэслэн энэхүү Протоколын тавдугаар зүйлд дурдсан малын өвчинөөс урьдчилан сэргийлэх, хянах тогтолцооны талаарх мэдээллийг хүргүүлэх бөгөөд тавдугаар зүйлд дурдсан болон Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын (DMAЭМБ) зөвлөмжид мэдээлвэл зохих өвчинөөр тодорхойлогдсон малын өвчиний нөхцөл байдлын талаар БНХАУ-ын ГЕГ-т мэдэгдэнэ.

Монгол Улсын ГЕГ нь БНХАУ-ын ГЕГ-т Монгол Улсын эмийн үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө болон эмийн үлдэгдлийн тайланг хүргүүлнэ.

Шаардлагатай тохиолдолд БНХАУ-ын ГЕГ-ын мэргэжлийн баг нь дээр дурдсан бодит тогтолцоо, зохицуулалтын байдалд газар дээр нь хяналт шалгалт хийхэд Монгол Улсын ГЕГ-аас холбогдох дэмжлэгийг үзүүлнэ.

**4 дүгээр зүйл**

Монгол Улсын ГЕГ нь дараах зүйлсийг баталгаажуулна. Үүнд:

1. Энэхүү Протоколын хоёрдугаар зүйлд заасан сүү, сүүн бүтээгдэхүүний түүхий эд нь үхэр, хонь, ямаанаас гаралтай байна.
2. Монгол Улсын ГЕГ нь сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын үр дүнтэй тогтолцоог бий болгох бөгөөд түүхий сүү нь эрүүл малын түүхий эдээс гаралтай гэдгийг баталгаажуулж, энэхүү Протоколын тавдугаар зүйлд заасан шаардлагуудыг хангасан байна.
3. Монгол Улсын ГЕГ нь сүү, сүүн бүтээгдэхүүний ул мөрийг үр дүнтэйгээр мөшгөн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг тогтооно.
4. Монгол Улсаас БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүний түүхий сүү нь зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй байна.

### 5 дугаар зүйл

БНХАУ-д экспортлогдох сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх түүхий сүүний түүхий эд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Дараах нөхцөлүүдийг хангасан аж ахуйгаас гаралтай байна. Үүнд:
  - а) Сааль авахаас нэг сарын өмнө тухайн аж ахуйд шүлхий өвчин болон түүний сэжигтэй тохиолдол гараагүй байх.
  - б) Сааль авах үед аж ахуйд эмнэл зүйн хувьд боом өвчин (anthrax) болон түүний сэжигтэй тохиолдол илрээгүй байх.
  - в) Аж ахуйд үхрийн сүрьеэ (bovine tuberculosis), иж сүрьеэ (para tuberculosis), үхрийн мялзан (rinderpest), рифт хөндийн халуурал (rift valley fever), бог малын мялзан (peste des petits ruminants), хонь, ямааны цэцэг (sheep pox, goat pox), үхрийн цээж өвчин (contagious bovine pleuropneumonia) гараагүй байх.
  - г) Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналтад байдаг аж ахуй байх.
  - д) Аж ахуйнууд болон түүнийг тойрон хүрээлсэн газар нь малын өвчний улмаас ДМАЭМБ-ын Кодын болон Монгол Улсын Малын эрүүл мэндийн хууль тогтоомжийн дагуу хорио цээрийн хязгаарлалтад ороогүй байх.
2. Мал амьтан нь Монгол Улс болон БНХАУ-д хориглосон тэжээлээр тэжээгдээгүй байх.
3. Монгол Улсын ХХААХҮЯ-аас баталсан үндэсний жилийн үлдэгдлийн хяналтын төлөвлөгөөг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж нь түүхий сүүнд шинжилгээ хийдэг байх. Үндэсний жилийн үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө болон түүхий сүүнд хийсэн шинжилгээний хариугаар БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүн дэх малын эм, пестицидийн үлдэгдэл болон бусад хортой, аюултай бодисын үлдэгдлийн хэмжээ БНХАУ-ын стандартад заасан дээд

хязгаарыг даваагүй байх.

### 6 дугаар зүйл

БНХАУ-д сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгж нь Монгол Улсын ГЕГ-аас зөвшөөрөл олгогдсон, эсвэл бүртгэгдсэн, хяналтад байх бөгөөд Монгол Улс болон БНХАУ-ын малын болон нийтийн эрүүл мэндийн шаардлагуудыг хангасан байна. Үйлдвэрлэгчдийн хэрэглэсэн түүхий сүү нь энэхүү Протоколын тавдугаар зүйлд заасан шаардлагуудыг хангасан аж ахуйгаас гаралтай байна.

БНХАУ-ын ГЕГ нь БНХАУ-д сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгжийг “БНХАУ-ын Хүнсний аюулгүй байдлын тухай хууль”, “БНХАУ-д хүнс импортлох гадаадын хүнсний үйлдвэрийн бүртгэлийн журам”-ыг тус тус үндэслэн бүртгэнэ. БНХАУ-д бүртгэгдээгүй сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортолж болохгүй.

### 7 дугаар зүйл

Монгол Улсын эрх бүхий улсын байцаагч дараах зүйлсийг баталгаажуулна. Үүнд:

1. Монгол Улсын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Монгол Улсын холбогдох хууль, журмын дагуу БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүнийг хийсэн түүхий сүүний аж ахуйд албан ёсны хяналт шалгалт, хорио цээрийг хэрэгжүүлнэ.
2. Сүү, сүүн бүтээгдэхүүний нийт аж ахуй нь энэхүү Протоколын тавдугаар зүйлд заасан шаардлагыг хангасан бөгөөд мал амьтан нь эрүүл байх.
3. Монгол Улсын үндэсний жилийн үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө болон түүхий сүүнд хийсэн шинжилгээний хариугаар БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүн дэх малын эм, пестицидийн үлдэгдэл болон бусад хортой, аюултай бодисын үлдэгдлийн хэмжээ БНХАУ-ын стандартад заасан дээд хязгаарыг даваагүй байх.
4. Сүү, сүүн бүтээгдэхүүн (нунтаг ангир уургаас бусад)-ий орц дахь түүхий эдэд ангир уураг (жилбэ), антибиотик хэрэглэсэн үеийн болон түр зогсоох үеийн сүү болон чанарын өөрчлөлт орсон сүү агуулагдаагүй байх.
5. Бүтээгдэхүүн нь дараах боловсруулах аргуудын аль нэгээр хийгдсэн байна. Үүнд:
  - a) Хамгийн багадаа  $132^{\circ}\text{C}$  хэмд дор хаяж 1 секунд ариутгах горимыг хэрэглэх /хэт өндөр хэм UHT/,
  - b) Хэрэв сүүний pH утга нь 7.0-оос доош бол хамгийн багадаа  $72^{\circ}\text{C}$  хэмд дор хаяж 15 секунд ариутгах горимыг хэрэглэх (өндөр хэмд богино хугацаа HTST),
  - c) Хэрэв сүүний pH утга нь 7.0-оос дээш бол HTST горимыг хоёр удаа хэрэглэнэ.

6. Сүү, сүүн бүтээгдэхүүн нь Монгол Улсын ГЕГ-ын хяналтад Монгол Улсын үйлдвэрт үйлдвэрлэгдэж, Монгол Улс болон БНХАУ-ын хууль, тогтоомжид нийцсэн байх.

7. Бүтээгдэхүүн нь БНХАУ-ын хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн, аюулгүй, эрүүл, хүний хэрэгцээнд тохирсон байх.

8. Хэрэв дээрх 1-ээс 7 дугаар шаардлагуудыг зөрчсөн зөрчил илэрвэл Монгол Улсын ГЕГ-аас БНХАУ-ын ГЕГ-т нэн даруй мэдэгдэж, холбогдох үйлдвэрлэгчийн бүх барааг БНХАУ-д экспортлохыг түдгэлзүүлж, ул мөрийг мөрдөн шалтгааныг тогтоож, бохирлогдсон байж болзошгүй бүтээгдэхүүнийг эргүүлэн татах зэрэг арга хэмжээг авна.

### **8 дугаар зүйл**

БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүнийг энэхүү Протоколын 5 болон 7 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангаагүй сүү, сүүн бүтээгдэхүүнүүдтэй хамт боловсруулахыг хориглоно. БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалт нь шатлал тус бүрт хялбар танигдахаар байж, энэхүү Протоколын нөхцөл шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортолно.

### **9 дүгээр зүйл**

БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүнийг БНХАУ-ын стандартад нийцсэн шинэ материалд савласан байна. Гадна талын савалгаан дээр үйлдвэрлэсэн үйлдвэрийн бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ. Дотор савалгаа нь БНХАУ-ын холбогдох хууль, журам, стандартад нийцсэн байх бөгөөд шошго дээр бүтээгдэхүүний гарал үүслийн улс, бүтээгдэхүүний нэр, үйлдвэрлэгчийн бүртгэлийн дугаар, нэр, хаяг, холбоо барих дугаар, үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа, хадгалах горим болон цэвэр жин зэргийг тусгасан байна.

### **10 дугаар зүйл**

БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүн нь савалалт, хадгалалт, тээвэрлэлтийн бүхий л үйл явцад эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх ба хортой, аюултай бодисуудаар бохирлогдохоос сэргийлэгдсэн байна. Барааг ачсаны дараа чингэлгийг лацдах ба лацны дугаарыг эрүүл ахуйн гэрчилгээн дээр бичсэн байна. Тээвэрлэлтийн явцад бүтээгдэхүүний савалгаа задарч, онгойж, солигдоогүй байна.

### **11 дүгээр зүйл**

БНХАУ-д экспортлох сүү, сүүн бүтээгдэхүүний ачилт бүрт Монгол Улсын холбогдох байгууллагаас “Эрүүл ахуйн гэрчилгээ” олгогдсон байх бөгөөд, уг бүтээгдэхүүн нь БНХАУ-ын малын болон нийтийн эрүүл мэндтэй холбоотой хууль, тогтоомжуудын шаардлагууд болон энэхүү Протоколын холбогдох холбогдох журамд нийцсэн гэдгийг баталгаажуулсан байна. Монгол Улсын холбогдох байгууллагаас олгосон “Эрүүл ахуйн гэрчилгээ” нь зөвхөн Монгол Улс дахь үйлдвэрлэгчийн үйлдвэрлэж, боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүнд

олгоно.

Эрүүл ахуйн гэрчилгээ нь монгол, хятад, англи хэл дээр бичигдсэн байна. Гэрчилгээний хэлбэр, агуулгыг талууд харилцан тохиролцоно.

Эрүүл ахуйн гэрчилгээний агуулгад засвар өөрчлөлт хийхгүй бөгөөд Монгол Улсын холбогдох байгуулагын албан ёсны тамга, тэмдэг болон байцаагчийн гарын үсэгтэй байх ба хүрэх газрыг БНХАУ гэж бичсэн байна.

## 12 дугаар зүйл

Түүхий сүүг гарган авсан сүү, сүүн бүтээгдэхүүний аж ахуйд энэхүү Протоколын тавдугаар зүйлд заасан ямар нэгэн халдварт өвчин гарсан тохиолдолд эсвэл боловсруулах үйлдвэрт хүний эрүүл мэндэд сөргөөр нелөөлөх ноцтой бохирдол гарсан тохиолдолд дээрх аж ахуй эсвэл боловсруулах үйлдвэрээс гарсан сүү, сүүн бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлох үйл ажиллагааг нэн даруй зогсоож, шаардлагад нийцээгүй бүтээгдэхүүнийг яаралтай эргүүлэн татаж, БНХАУ-ын ГЕГ-т холбогдох мэдээллийг хүргүүлнэ.

Халдварт өвчин бүрэн устсан эсвэл бохирдсон үйл явцыг бүрэн арилгасны дараа дээр дурдсан сүү, сүүн бүтээгдэхүүний аж ахуй эсвэл боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг дахин сэргээхийн тулд Монгол Улсын ГЕГ-аас БНХАУ-ын ГЕГ-т халдварт өвчний тохиолдол эсвэл бохирдсон үйл явц, хийсэн хянан магадлагаа, урьдчилан сэргийлэлт, хяналтын арга хэмжээний талаар мэдээлэл агуулсан нарийвчилсан тайланг хүргүүлнэ. БНХАУ-ын ГЕГ нь Монгол Улсын ГЕГ-аас хүргүүлсэн тайлантай танилцсаны дараа дээр дурдсан сүү, сүүн бүтээгдэхүүний аж ахуй эсвэл боловсруулах үйлдвэрийн экспортыг дахин сэргээх эсэхийг шийдвэрлэнэ. Эдгээр арга хэмжээ нь зөвхөн дээр дурдсан сүү, сүүн бүтээгдэхүүний аж ахуй эсвэл боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд чиглэсэн байна.

Хэрэв импортолсон сүү, сүүн бүтээгдэхүүнүүд нь энэхүү Протоколын шаардлагад нийцээгүй болохыг БНХАУ-ын ГЕГ тогтоовол Монгол Улсын ГЕГ-т нэн даруй мэдэгдэж, бүтээгдэхүүнийг буцаах, устгах эсвэл бусад арга хэмжээг авна. Монгол Улсын ГЕГ нь БНХАУ-ын ГЕГ-тай хамтран шалтгааныг тодруулах, хэрхэн шийдвэрлэх талаар хамтран ажиллах бөгөөд үүнд мөн бас БНХАУ-ын ГЕГ нь бусад бохирдсон байж болзошгүй бүтээгдэхүүнүүдийг буцаан татах зэрэг авч хэрэгжүүлсэн засаж залруулах арга хэмжээ багтах бөгөөд дахин адил төрлийн асуудал үүсэхээс сэргийлэ.

## 13 дугаар зүйл

Энэхүү Протоколд дурдсан сүү, сүүн бүтээгдэхүүн гэдэгт үндсэн түүхий эдийг сүүнээс гаргаж авсан боловсруулсан хүнс, ариутгасан сүү, өөрчлөлт оруулсан сүү, исгэсэн сүү, бяслаг, зөөхий, цөцгийн тос, усгүйжүүлсэн сүү, өтгөрүүлсэн чихэрлэг сүү, хуурай сүү, хуурай шар сүү, шар сүүний уургийн нунтаг, үхрийн ангир уургийн нунтаг зэрэг багтана.

Монгол Улсын ГЕГ нь БНХАУ-д экспортолж буй сүү, сүүн бүтээгдэхүүн энэхүү Протоколын долдугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан дулааны аргаар бүрэн боловсруулагдсан болохыг баталгаажуулна

#### **14 дүгээр зүйл**

Энэхүү Протоколд хоёр тал харилцан бичгээр зөвшилцэж, нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлтийн хүчинтэй хугацааг хоёр тал зөвлөлдөн шийдвэрлэнэ. Тэдгээр нэмэлт өөрчлөлтууд нь энэхүү Протоколын салшгүй хэсэг байна.

#### **15 дугаар зүйл**

Монгол Улсын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ-ын аль нэг тал зөвлөлдөх хүсэлтийг албаны шугамаар хэдийд ч гаргаж болно. Зөвлөгөөн хийх цаг, газрыг Талууд хэлэлцэн шийдвэрлэнэ.

#### **16 дугаар зүйл**

Энэхүү Протокол нь гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 6 сарын өмнө аль нэг тал нь нөгөө талдаа Протоколд нэмэлт өөрчлөлт оруулах болон дуусгавар болох талаарх саналаа бичгээр хургуулээгүй тохиолдолд энэхүү Протокол нь дараагийн 5 жилд аяндаа сунгагдах болно.

Энэхүү Протоколыг Улаанбаатар, Бээжин хотноо 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр монгол, хятад, англи хэлээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

Эх бичвэрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД  
УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ